

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2019 оны 5-р сарын 28
Тендер шалгаруулалтын дугаар: МРЦМ/201901146

“Монголросцветмет” ТӨҮГ нь эрх бүхий тендерт оролцогчдоос Бор-Өндөрийн УБҮ-ийн дулааны станцын KE25-14C №2 зуухны их засварын ажлыг гүйцэтгэх тухай тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичигтэй танилцана уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө **50 000.00** төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байна. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жилийн борлуулалтын орлогын дундаж нь тендерийн үнийн саналын мөнгөн дүнгийн 50 хувиас багагүй

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: тендерийн үнийн саналын мөнгөн дүнгийн 50 хувиас багагүй

Аудитлагдсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: 2017, 2018 он

Сүүлийн 2 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын жагсаалт, өртөг: ирүүлнэ

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: шаардлагатай. (зуух, даралтат сав, шугам хоолойн угсралт, засвар үйлчилгээ эрхлэх)

Тендерийн хамт **5 5000 000.00** төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2019 оны 7-р сарын 01-ны өдрийн 15:00 цагаас** өмнө www.tender.gov.mn хаягаар цахимаар ирүүлэх ба тендерийг **2019 оны 7-р сарын 01-ны өдрийн 15:05 цагт** цахимаар нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх: **эрхгүй**

Дотоодны давуу эрх тооцох эсэх: Тооцохгүй

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

“Монголросцветмет” ТӨҮГ, УБ,БЗД, Энхтайваны өргөн чөлөө-98
утас/факс:450060+138, 243, факс: 458380